

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.06.16

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Долоо хоногийн эхэнд худалдааны хэлэлцээний нааштай мэдээлэл, 5-р сарын инфляцийн таамгаас доогуур өсөлт зэрэг эерэг үзүүлэлтүүд зах зээлийг дэмжиж, индексүүд өсөлттэй байсан.
- Баасан гарагийн өглөө, Израиль улс Ираны цөмийн байгууламж болон цэргийн удирдлагууд руу агаарын довтолгоо хийснээр хөрөнгийн зах зээлийг унагалаа.
- Хятадын хэрэглээний үнийн индекс (CPI) өмнөх оны мөн үеэс дөрөв дэх сардаа дараалан буурсан нь үл хөдлөх хөрөнгө болон бараа бүтээгдэхүүний эрэлт сул байгааг илтгэлээ.
- АНУ, БНХАУ-ын албан ёсны худалдааны урьдчилсан тохиролцоо Лондонд хийгдсэн уулзалтаар гарч, хөрөнгө оруулагчдын итгэл сэргээж, Хятадын хувьцааны үнэ долоо хоногт дээд цэгт хүрсэн ч дэлгэрэнгүй мэдээлэл болон удирдагчдын баталгаажуулалт шаардлагатай хэвээр байна.



S&P 500 индексийн 2025 оны таамаглал

| | |
|---------------------|--------------|
| Deutsche Bank | 7,000 |
| Société Générale | 6,750 |
| BMO Capital Markets | 6,700 |
| Bank of America | 6,666 |
| Barclays | 6,600 |
| RBC Capital Markets | 6,600 |
| Wells Fargo | 6,500 |
| Citigroup | 6,500 |
| Goldman Sachs | 6,500 |
| Morgan Stanley | 6,500 |
| JPMorgan Chase | 6,500 |
| UBS | 6,400 |
| Дундаж | 6,678 |

Хэрэв Биткойны ханш 100к ам.долларын түвшинг доош эвдэхгүйгээр 108к түвшнийг эвдэж, 112к түвшнээс дээш удаан тогтвол урт хугацааны bullish pattern дэмжиж 149к хүртэл өсөх боломжтой байна.





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.06.09-06.14

ОЙРХИ ДОРНОДЫН ХУРЦАДМАЛ БАЙДЛЫН УЛМААС ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ УНАВ

АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт уналаа. Жижиг, дунд компаниудын хувьцааг багтаадаг S&P MidCap 400 болон Russell 2000 индексүүд тус тус 1.46%, 1.49%-иар буурсан бол Dow Jones Industrial Average 1.32%-иар унаж, оны эхний түвшингээс доош унасан байна. Харин S&P 500 болон Nasdaq Composite индексүүд бага хэмжээгээр унажээ.


Долоо хоногийн эхээр худалдааны яриа хэлэлцээний нааштай мэдээлэл, хүлээлтээс давсан макро эдийн засгийн үзүүлэлтүүд зах зээлийг дэмжиж, голлох индексүүд пүрэв гараг хүртэл өргөн хүрээтэй өсөлттэй байсан. АНУ-БНХАУ-ын хоёр талын худалдааны хэлэлцээний хүрээнд түр тохиролцоонд хүрсэн тухай мэдээ, мөн Сангийн сайд Скотт Бессент-ийн тарифын 90 хоногийн хойшлуулалт “шударгаар хэлэлцэж буй” орнуудад сунгагдаж болзошгүй гэсэн мэдэгдэл нь зах зээлийн эерэг хүлээлтийг улам тэтгэжээ.

Гэвч баасан гарагийн өглөө, Израиль улс Ираны цөмийн байгууламж болон цэргийн удирдлагууд руу агаарын довтолгоо хийсэн талаар мэдээлэл цацагдсанаар уур амьсгал эрс өөрчлөгдөв. Довтолгоо үргэлжилнэ гэсэн амлалтад, Иран хариу цохилт өгсөн гэж мэдээлэгдсэн. Үүний улмаас тосны үнэ огцом өсч, эрчим хүчний салбарын хувьцаа богино хугацаанд ашигтай байсан ч өргөн хүрээний индексүүд огцом буурч, өмнөх өдрүүдийн ололтоо бүрэн алдсан байна.

Долоо хоногийн эхний хагас дахь өөдрөг хандлагад 5-р сарын инфляцийн түвшин таамгаас бага гарсан нь нөлөө үзүүлжээ. АНУ-ын Хөдөлмөрийн статистикийн товчоо (BLS)-ноос мэдээлснээр, 5-р сард хэрэглээний үнийн индекс (CPI) сард 0.1% өссөн нь 4-р сарын 0.2%-иас буурсан, мөн зах зээлийн 0.3%-ийн таамаглалаас доогуур гарсан байна.

Golomt_Capital published on TradingView.com, Jun 16, 2025 00:07 UTC-4

Nasdaq 100 Index - 1D - NASDAQ Q1:1,675.94 K1:1,838.47 L21,591.11 C21,631.04 -282.28 (-1.29%) -282.28 (-1.29%)



TradingView



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.06.09 – 06.14

ХЯТАДЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЕФЛЯЦЫН ДАРАМТАД ОРЖ, БУУРАЛТТАЙ ХААГДЛАА

2025 оны 6-р сарын сүүлийн байдлаар Хятадын дотоодын хөрөнгийн зах зээл бууралттай хаагдсан нь эдийн засагт тулгараад буй дефляцын дарамтыг дахин баталлаа. CSI 300 индекс болон Шанхайн нийлмэл индекс тус бүр 0.25%-иар буурсан бол Хонгконгийн Hang Seng индекс харьцангуй өсөлттэй байж, 0.42%-ийн өсөлт үзүүлэв.

Тавдугаар сард Хятадын хэрэглээний үнийн индекс (CPI) өмнөх оны мөн үеэс дөрөв дэх сардаа дараалан буурсан талаар тус улсын Статистикийн газар мэдээлэв. Үүнээс гадна, үйлдвэрлэлийн үнэ (PPI) нийтдээ 32 сар дараалан буурч, сүүлийн хоёр жилд байгаагүй хамгийн огцом уналтад орсон байна (Bloomberg). Ийм удаан үргэлжилж буй дефляц нь үл хөдлөх хөрөнгийн хямралаас шалтгаалсан дотоодын эрэлтийн хомсдолтой холбоотой бөгөөд Хятадын эдийн засгийн суурь хүндрэл хэмээн үнэлэгдэж байна.

Хэдий тийм боловч, АНУ, БНХАУ-ын албаныхан өнгөрсөн долоо хоногт Лондонд болсон хоёр өдрийн уулзалтын дараа худалдааны зөрчлийг намжаах урьдчилсан тохиролцоонд хүрсэн мэдээ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээжээ. Үүний үр дүнд лхагва гарагт Хятадын хувьцааны үнэ долоо хоногийн дээд цэгт хүрсэн ч тохиролцооны дэлгэрэнгүй мэдээлэл хараахан тодорхойгүй бөгөөд хоёр улсын удирдагчдын баталгаажуулалт шаардлагатай байгаа аж.





































Хятадын зах зээлд өсөлтийн трендийн инерци саарч байгаа ч 200 өдрийн хөдлөх дундаж ханш (200DMA) дээрээ бат дэмжлэг авч, өсөлтийн бүтцээ хадгалж байна. Үнийн өсөлт үргэлжилж буй үед RSI зэрэг импульсийн индикаторууд divergence үзүүлж байгаа нь трендийн эргэлтийн анхны дохио байж болзошгүй. Иймд 10%-ийн бууралт руу орох засварын эрсдэл байна.

Golomt_Capital published on TradingView.com, Jun 15, 2025 23:58 UTC-4

Hang Seng Index - 1W - HSI O23,791.79 H23,937.34 L23,718.72 C23,869.98 -22.58 (-0.09%) -22.58 (-0.09%)



Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд

| E EARNINGS WHISPERS | | Most Anticipated Earnings Releases | | | | | | | |
|--|---|---|--|--|---|---|---|---|-------------|
| | | for the week beginning | | | | | | | |
| | | June 09, 2025 | | | | | | | |
| Monday | | Tuesday | | Wednesday | | Thursday | | Friday | |
| Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close |
| <div>GME</div> <div></div> <div></div> | <div>CASY</div> <div></div> <div></div> <div></div> <div></div> <div></div> <div>LIMONEIRA</div> <div></div> <div></div> <div></div> <div>skillsoft</div> <div></div> <div>COMTECH</div> | <div>UNFI</div> <div>BETTER FOOD. BETTER FUTURE.</div> <div></div> <div></div> <div></div> <div>THE J.M. SMUCKER CO.</div> <div></div> <div></div> | <div>GME</div> <div></div> <div></div> <div></div> <div></div> <div>STITCH FIX</div> <div></div> <div></div> | <div>CHWY</div> <div></div> <div></div> <div>VICTORIA'S SECRET</div> <div></div> <div>Vera Bradley</div> <div></div> <div></div> <div></div> | <div>ORCL</div> <div></div> <div></div> <div>OXFORD</div> | <div>LOVE</div> <div></div> <div></div> <div>HOOKER</div> <div></div> | <div>ADBE</div> <div></div> <div></div> | <div>MNY</div> <div></div> | |
| http://eps.sh/cal | | | | | | | | © 2025 Earnings Whispers | |

Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд

| E EARNINGS WHISPERS | | Most Anticipated Earnings Releases | | | | | | | |
|---|--|--|---|---|---|-------------|-------------|--------------------------|-------------|
| | | for the week beginning June 16, 2025 | | | | | | | |
| Monday | | Tuesday | | Wednesday | | Thursday | | Friday | |
| Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close | Before Open | After Close |
| <div>AIOT</div> <div>POWERFLEET</div> <div>RNW</div> <div>ReNew POWER</div> <div>PETS</div> <div>PetMeds</div> <div>HBT</div> <div>HIGHTIDE RP L</div> <div>RF INDUSTRIES</div> | <div>APPS</div> <div>digital turbine</div> <div>LEN</div> <div>LENNAR</div> <div>PET</div> <div>PetMeds</div> <div>HBT</div> <div>HIGHTIDE RP L</div> <div>RF INDUSTRIES</div> | <div>JBL</div> <div>JABIL</div> <div>TEN</div> <div>TEN LTD</div> <div>ANTA</div> <div>ANTALPHA</div> <div>VINC</div> <div>VINCE.</div> <div>WY</div> <div>WILEY</div> | <div>XAIR</div> <div>Beyond Air</div> <div>L2B</div> <div>LABOY</div> <div>VION</div> <div>VistaGen Therapeutics</div> <div>WY</div> <div>WILEY</div> | <div>ACB</div> <div>AURORA</div> <div>LVO</div> <div>LIVEXONE</div> <div>GMS</div> <div>GMS</div> <div>KFY</div> <div>KORN FERRY</div> <div>SWB</div> <div>Smith & Wesson</div> | <div>KR</div> <div>Kroger</div> <div>ACN</div> <div>accenture</div> <div>DRI</div> <div>DARDEN RESTAURANTS</div> <div>KMX</div> <div>CARMAX</div> | | | | |
| http://eps.sh/cal | | | | | | | | © 2025 Earnings Whispers | |